



АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 03 сарын 05 өдөр

Дугаар 6/22

Улаанбаатар хот

Н.Нармандахад сахилгын шийтгэл
ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.3.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 131.1, 131.1.1, Архивын ерөнхий газрын хөдөлмөрийн дотоод журмын 13.1, 13.3, Норовын Нармандахтай 2019 оны 02 сарын 18, 03 сарын 04-ний өдөр хийсэн сонсох ажиллагааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Архивын ерөнхий газрын Санхүү, аж ахуйн хэлтсийн жолооч Н.Нармандах нь Хөдөлмөрийн дотоод журмын 8.3, 8.9, Б-Х-09 дугаартай Хөдөлмөрийн хугацаатай гэрээний 8.1.5 дахь заалтыг зөрчиж 2019 оны 02 дугаар сарын 18, 28-ны өдрүүдэд ажлын цагаар ажлын байраа орхиж явсан зөрчлийг гаргасан болох нь байгууллагын дотоод хяналт, шалгалтаар тогтоогдсон тул Н.Нармандахад сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Өдөр тутмын үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг чанд мөрдөж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг Н.Нармандахад үүрэг болгосугай.

3. Дээрх зөрчлийг гаргахгүй байхыг нийт албан хаагчдад анхааруулж, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын газар /Л.Уянга/-т, харъяалах нэгжийн албан хаагчдын ажлын цаг ашиглалтад хяналт тавьж ажиллахыг зохион байгуулалтын бүтцийн нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.

4. Сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэрийг ажилтан үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай гомдлоо энэхүү шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор шүүхэд гаргаж болохыг дурдсугай.

ДАРГА



С.ЭНХБААТАР

Tushaal
368110182